



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2016 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

┌ Хүн амын дундах тандалт судалгааны ┐
заавар батлах тухай

Эрүүл мэнд, спортын сайдын “Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн стратеги төлөвлөгөө (2015-2020 он) батлах тухай” 2015 оны 82 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хүн амын дундах тандалт судалгааны зааврыг I, тандалт судалгааны арга, аргачлалыг II, тандалт судалгааны тайлан бичих дарааллыг III хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн тусламжийн албаны дарга /У.Нармандах/, нийслэл, аймгуудын Зоонозын өвчин судлалын төвийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Байгалийн голомтот, шинэ сэргэн тархаж буй зарим халдварт өвчний хүн амын дундах тархвар зүйн тандалт судалгааны арга зүйн заавар” батлах тухай БГХӨСҮТ-ийн захирлын 2010 оны а/78 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хүний нөөц, статистикийн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэгч /Д.Цэрэнноров/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

Төвийн захирлын оны
03 дүгээр сарын 10 өдрийн
А/114 дугаар тушаалын хавсралт



ХҮН АМЫН ДУНДАХ ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ЗААВАР

Боловсруулсан:

Б.Уянга, ЗӨСҮТ-ийн ахлах зэрэгтэй тархвар судлагч, НЭМ-ийн магистр

Д.Отгонбаяр, ЗӨСҮТ-ийн ахлах зэрэгтэй тархвар судлагч, их эмч

Хянасан:

Ж.Мягмар PhD, тэргүүлэх зэрэгтэй нян судлагч, клиникийн профессор,

Д.Цэрэнноров PhD, ЗӨСҮТ-ийн НЭМЭША-ны дарга

УЛААНБААТАР 2016 ОН

НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Асуумж судалгаа: Хүн амын мэдлэг, хандлагыг үнэлэх, эрсдлийг тогтоох асуулга юм.

Нэг агшны судалгаа:

Тодорхой хүн амын дунд тодорхой хугацаанд өвчин ба эрсдэлт хүчин зүйл хэрхэн тархсаныг зэрэг судлах явдал юм.

Тэргүүлэх чиглэлийг тогтоох гэдэг нь:

Халдварт өвчний үндэсний тандалтын системийг бэхжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор түүнийг хэрэглэхэд чиглэнэ.

Хүн амын дундах тандалт: Мэдээ, мэдээллийг цуглуулж, хүн амын дундах урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, тайлбарлах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаа юм.

Зоонозын өвчин: Мал амьтнаас хүнд халдварладаг өвчин юм.

Халдваржилт: Шинжилж буй өвчний эерэгбие тодорхойлогдсон хүний тоог нийт шинжилсэн хүний ийлдсийн тоонд хуваагаад хувиар тооцсон үзүүлэлт.

ҮНДЭСЛЭЛ

XXI зуун гарсаар дэлхий дахинд жил бүр 14 сая хүн халдварт өвчнөөр өвчилж байгаагаас 70-80%-ийг вирусийн гаралтай халдварт өвчин эзэлж байна. Хүнд халдварт өвчин үүсгэдэг 1400 зүйлийн үүсгэгчдийн 60 орчим хувь нь мал, амьтны гаралтай байдаг байна. Сүүлийн жилүүдэд эбола, нипах, ласса, АЦХАХ, гахайн томуугийн H5N1, H1N1 хэвшинж, Мэрс Корона вирусийн халдвар гэх мэт шинэ халдварууд сэргэж байна (www.who.int/org).

Зоонозын өвчний тандалтын системд тарваган тахал, боом, галзуу, хачигт халдвар өвчний тохиолдолд суурилсан тандалт 1931 оноос, тарваган тахал, бусад зоонозын халдварын байгалийн голомтын тандалт судалгаа 1959 оноос, хүн амын дунд зоонозын өвчний мэдлэг хандлагыг тогтоох тандалт судалгааг 2006 оноос эхлэн хийж иржээ. Одоогийн байдлаар тарваган тахал, боом, галзуу, хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, хумхаа зэрэг 7 өвчний хүний өвчлөлийг албан ёсоор бүртгэдэг ч байгалийн голомтын тандалт судалгаагаар эризепелойд, хуурмаг сүрьеэ, пастереллөз, листериоз, хулгана тахлын өсгөврийг мэрэгч амьтдаас, анаплазмоз, эрлихиоз, ку халуурал, баруун нилийн халуурал, денгийн өвчний ДНХ-г дамжуулагчдаас, хүн амын дунд хулгана тахал, баруун нилийн халуурал, ку халуурал, листериоз, токсоплазмоз, лептоспироз, анаплазмоз, хуурмаг сүрьеэ зэрэг өвчний халдваржилтыг илрүүлэн тухайн өвчний байгалийн голомт оршин буйг тогтоогоод байна.

Иймд хүн амын гуравны нэг нь хөдөө орон нутагт нүүдлийн мал аж ахуй, газар тариалан эрхлэн байгальтай ойр амьдардаг онцлогтой Монгол улсын хувьд зоонозын өвчин нь хүн амын эрүүл мэнд болон Үндэсний аюулгүй байдалд ноцтой нөлөөлөх эрсдэлтэй учир хүн амын дунд байгалийн голомтот зоонозын өвчний мэдлэг мэдлэг хандлага, эрсдэл халдварлжилтыг тодорхойлж өвчний тархвар зүйн онцлог, тархалтын түвшинг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөх нь зүйтэй байна.

Мөн Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 82 дугаар “Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн стратеги төлөвлөгөө (2015-2020 он)” тушаалыг хэрэгжүүлэхээр зоонозын өвчний хүн амын дундах тандалтын зааврыг боловсруулах зорилт тавилаа.

Зорилго: Хүн амын дундах байгалийн голомтот зоонозын өвчний мэдлэг хандлага, тархалтыг тогтоож, урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах

Хэрэгжүүлэгч байгууллага: ЗӨСҮТ, орон нутгийн ЗӨСТ-ийн тархвар судлагч, эмч, мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

ТАНДАЛТ СУДАЛГААНЫ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг шаардлага

- 1.1. Энэхүү зааврыг зоонозын өвчний хүн амын дундах тандалт судалгааг хийхэд баримтлах бөгөөд орон нутгийн ЗӨСТ, ЗӨСҮТ хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Тандалт судалгааны ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ. Зардлыг тухайн байгууллага жилийн төсөвт тусгана.
- 1.3. Орон нутгийн ЗӨСТ-үүд зоонозын өвчний тандалтын тэргүүлэх чиглэлийг тогтоосныг үндэслэн хүн амын дундах тандалт судалгааг жил бүр төлөвлөн гүйцэтгэнэ.
- 1.4. Тандалт судалгааг гүйцэтгэхдээ тухайн орон нутгийн онцлогт тохируулан судалгааны аргуудыг сонгож, асуумж судалгааг боловсруулан хүн амын мэдлэгийн түвшинг тогтоож мэдээлэл, сургалт сурталчилгааны хэрэгцээг төлөвлөнө.
- 1.5. Судалгаа, шинжилгээний зорилгоор болон шаардлагатай тохиолдолд (шинэ, шалтгаан тодорхойгүй өвчлөлийг тандах г.м) тухайн бүс нутгийн хүн амаас цусны ийлдэс цуглуулж зорилтот өвчний хүн амын дундах халдваржилтыг тогтооно.
- 1.6. Тандалт судалгаагаар цуглуулсан хүний цусны ийлдсийг судалгаа хийгдэж дууссанаас хойш 1 сарын дотор шинжлэн, үр дүнг эргэн мэдээлнэ.

Хоёр. Төлөвлөлт

- 2.1. Төлөвлөлтөд хүн амын дунд тандалт судалгаа хийх хэрэгцээг үнэлэн, судалгааны арга загварыг гарган, тандалт судалгаа хийх газар нутаг, хүн амыг сонгох, асуумжийн хуудас боловсруулах, ажлын удирдамж гаргах, анагаах ухааны ёс зүйн асуудал шийдвэрлүүлэх зэрэг ажлууд орно.
- 2.2. Тухайн орон нутгийн тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчнийг 3-5 жил тутамд тогтоож, байгалийн голомтын тандалт судалгааны үр дүн, мал, амьтны өвчлөлийн тохиолдол бүртгэгдсэн зэрэгт үндэслэн тандалт судалгааг хийнэ.

- 2.3. Асуумж судалгаанд зорилтот бүлгийн хүн амын 10-30%-ийг хамруулах ба асуумж судалгаанд оролцогчдоос санамсаргүй болон зориудын түүврийн аргаар 10 хүртэл хувьд нь цусны ийлдэс цуглуулна.
- 2.4. Тандалт судалгааны асуумжийг тухайн орон нутгийн онцлогт тохируулан тархвар судлагч эмч боловсруулан, батлуулж, тандалт судалгаанд ашиглана.
- 2.5. Төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээ судалгааны зорилгоор хийгдэж буй тандалт судалгааны үед хүн амаас цусны ийлдэс цуглуулах бол анагаах ухааны ёс зүйн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.

Гурав. Тандалт судалгааг гүйцэтгэх

- 3.1. Тандалт судалгааг тархвар судлагч эмч гүйцэтгэж, асуумж судалгааг оролцогчоос өөрийн биеэр нүүр тулсан ярилцлагын хэлбэрээр авна.
- 3.2. Тандалт судалгаанд оролцох хувь хүнд судалгааны талаар тайлбарлаж, өвчний мэдээллийн хуудсыг танилцуулна. Цусны ийлдэс авах хүнээс таниулсан зөвшөөрөл авч, гарын үсэг зуруулсан байна.
- 3.3. Цус авахдаа эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд стандартын дагуу захын хураагуур судаснаас 8-10 мл-ийг авч, ийлдсийг ялган эппиндорфийн хуруу шилэнд 1.7-1.8 мл-ээр хийж, +2-8 хэмд сорьц тээвэрлэх гурвалсан савлагааны системийг ашиглан тээвэрлэж лабораторид хүргэнэ. Сорьцыг хаяглахдаа хувийн дугаар, аймгийн код, сумын код, сорьцын дугаар, сорьц авсан он сар өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 3.4. Тандалт судалгаагаар авсан хүний цусны ийлдсийн дугаарыг асуумж судалгааны хуудсанд тэмдэглэнэ. Цусны ийлдсийг лабораторид хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор шинжилнэ.

Дөрөв. Тандалт судалгааны үр дүнг үнэлэх, дүгнэх

- 4.1. Асуумжаар цуглуулсан тоо мэдээг шивж, засварлан, кодлож мэдээлэл болгоно. Асуумжийн асуултуудын утгууд нь хүлээгдэж буй хэвийн хазайлтын хэмжээнд байгаа эсэхийг шалгана. Arc view, SPSS, Epi info программд оруулж боловсруулалт хийх ба мэдээллийн бааз үүсгэн хадгална. Статистикийн ямар арга хэрэгслийг

сонгох, хэрэглэх нь тохиромжтой вэ гэдэг нь судалгааны зорилго, зорилт, дүн шинжилгээ хийх хувьсагчийн хэлбэр, тоо, түүврийн хэмжээ болон бусад олон хүчин зүйлээс хамаарна. Зоонозын халдварт өвчний мэдлэг, дадал, хандлага тогтоох хүн амын давтамж, дундаж, тэдгээрийн стандарт алдаануудын үнэлэлтийг тооцно. Давтамж болон итгэмжит хязгааруудыг (95%CI) үзүүлэлт тус бүрээр тооцно.

- 4.2. Тоон мэдээг боловсруулахдаа нийт судалгаанд хамрагдсан хүн амын газар зүйн байршил, хүйс, нас (5 насаар ангилах), боловсрол, ажил эрхлэлт, мэргэжил болон мэдлэгийн хэсгийг эзлэх хувиар тооцон гаргана.
- 4.3. Мэдлэгийн зөв хариултууд нийлээд 100% байхаар тооцоолно. Зөв хариулт 70-аас дээш оноотой бол тухайн хүн амын дундах мэдлэгийн түвшин сайн, зөв хариулт 40-69 хүртэл оноотой бол тухайн хүн амын мэдлэгийн түвшин хангалтгүй, зөв хариулт 39-с доош оноотой бол тухайн хүн амын мэдлэгийн түвшин хангалтгүй байна гэж үзнэ.
- 4.4. Хандлага дадал, эрсдлийн асуумжийг өвчин тус бүр дээр тухайн бүс нутгийн онцлог хариултаар нь гаргаж, дадлыг өөрчлөх, эрсдлийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөнө.
- 4.5. Асуумж судалгааны хуудсын эх хувийг тайлангийн хамт архивын баримт болгон хадгална.
- 4.6. Зоонозын өвчний хүн амын дундах халдваржилтыг эрүүл хүн амаас цуглуулсан цусны ийлдсэнд тухайн судлаж буй өвчний эсрэг иммуноглобулин (IgG) хайх шинжилгээ хийж, лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн тогтооно.
- 4.7. Халдваржилтын түвшинг тооцохдоо эсрэгбие эерэг тодорхойлогдсон хүний тоог нийт шинжилсэн хүний тоонд харьцуулж хувиар тооцно.

$$X = \frac{n}{N} \cdot 100\%$$

X- Халдваржилтын хувь

n- Эсрэгбие эерэг тодорхойлогдсон хүний тоо

N – Нийт шинжилсэн хүний тоо

- 4.8. Эсрэгбие эерэг тодорхойлогдсон тохиолдолд газар зүйн мэдээлэл, нас хүйсийн онцлогийг тодорхойлж, дадал, хандлага, эрсдэл, тухайн газар нутгийн байгалийн


голомт, өмнөх тандалт шинжилгээний дүн зэрэгтэй холбон судална. Халдваржилтыг тухайн орон нутагт 3-5 жил тутамд тогтооно.

- 4.9. Лабораторийн шинжилгээний дүнгээр өвөрмөц эсрэгбиеийн таньц (IgG) эерэг хүнд өвчний сэжиг бүхий эмнэл зүйн шинжтэй тохиолдолд давтан ийлдэс авч лабораторийн шинжилгээнд хамруулах ба таньцын түвшин 4 дахин нэмэгдвэл тухайн хүнийг тухайн өвчний хурц хэлбэрээр өвчилсөн гэж үзэх бөгөөд эрүүл мэндийн үзлэгт хамруулж эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.10 Хэрэв давтан ийлдсийн эсрэгбиеийн таньц нэмэгдээгүй, сөрөг гарсан тохиолдолд хурц хэлбэрийн өвчлөл гэж үзэхгүй. Энэ нь тухайн өвчний дархлаатай, архаг халдвар гэж үзэх бөгөөд тухайн газар нутагт хүний өвчлөл бүртгэгдэх эрсдэлтэй гэж үзнэ. Тухайн хүнд эрүүл гэж эргэн мэдээлнэ. Байгалийн голомтын хяналт, тандалт судалгааг төлөвлөнө.
- 4.11. Хэрэв иммуноглобулин (IgG) сөрөг гарсан тохиолдолд тухайн хүнийг эрүүл гэж үзэн эргэн мэдээлнэ.

Тав. Үр дүнг тайлагнах, ашиглах, эргэн мэдээлэх

- 5.1. Тандалт судалгаа дууссанаас хойш 7 хоногийн дотор илтгэх хуудас бичнэ. Асуумж судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнгээр судалгаа дууссанаас хойш 1 сарын дотор тайлан бичиж, ЗӨСҮТ-д ирүүлнэ. Тайланг загварын дагуу бичнэ (Хавсралт 2).
- 5.2. Тандалт судалгаа гүйцэтгэсэн байгууллага нь тухайн тандалт судалгаанд хамрагдсан газрын харьяа эрүүл мэндийн байгууллага лабораторийн шинжилгээний дүнг хүргүүлнэ.
- 5.3. Асуумж судалгааны дүнд үндэслэн тухайн зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, дадал хандлагыг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах, хариу арга хэмжээг төлөвлөхөд ашиглах талаарх зөвлөмж боловсруулан, орон нутгийн ЭМБ, шийдвэр гаргагчдад хүргүүлнэ.

Төвийн захирлын 2016 оны
03 дүгээр сарын 10 өдрийн
А/14 дугаар тушаалын II хавсралт



ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

Судалгааны арга, загвар:

Мэдээ баримт цуглуулахдаа тоон ба чанарын судалгааны аргыг ашиглана. Тоон судалгаагаар зоонозын өвчний тархалт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн түвшин, бүтэц, онцлогыг хэмжин тоогоор илэрхийлнэ. Чанарын судалгаагаар зоонозын өвчний учир шалтгаан, гарал үүсэл, шийдвэрлэх арга замыг олон хүчин зүйлийн уялдаа холбоонд нь судална.

Тоон судалгаа буюу нэг агшны судалгаа (*cross-sectional studies*) нь тухайн хүнд судалж буй зоонозын өвчин байгаа эсэх, тэрээр судалж буй хүчин зүйлд өртсөн эсэхийг цаг хугацааны хувьд нэг агшинд тодруулна. Энэ судалгаагаар тодорхой хугацаанд хүн амын дунд тархсан зоонозын өвчлөлийн байдал, өвчинд нөлөөлөх хүчин зүйл, хүн амын мэдлэг, дадал, хандлагыг тогтооно. Асуумжийн аргаар аливаа үзэгдэл юмс, шалтгаан үр дагаврын үнэлэлт дүгнэлт авах, мэдээ, мэдээлэл цуглуулахад илүү тохиромжтой бөгөөд тухайн хүнээс хүссэн мэдээллээ бүрэн хэмжээгээр цуглуулах бололцоотой.

Чанарын судалгааг ярилцлагын аргаар явуулна. Ярилцлагыг бүлгийн болон ганцаарчилсан байдлаар зохион байгуулж тухайн сэдвээрээ шууд ярилцаж өргөн мэдээллийг авна. Ганцаарчилсан ярилцлагыг уг асуудлыг сайн мэдэх, ихээхэн мэдээлэл авч болох хүмүүсийг сонгон хүн нэг бүртэй ганцаарчилан уулзаж ярилцана. Хэсэг бүлэг хүмүүстэй нэг зэрэг ярилцаж тодорхой нэг асуудлаар тэдгээр хүмүүсийн дотор зонхилж байгаа бодол санааг судлах зорилгоор бүлгийн ярилцлага хийнэ. Бүлгийн ярилцлагыг дараах хэлбэрээр хийж болно.

Фокус бүлгийн ярилцлагыг 6-8 хүний бүрэлдэхүүнтэйгээр тодорхой асуудлыг тодруулах зорилгоор тухайн асуудалтай холбоо бүхий хүмүүсийг хамруулан чиглүүлэгчийн удирдлага дор ярилцлага хийнэ. Чиглүүлэгч нь ярилцлагыг идэвхжүүлэх, оролцогчдын санаа бодлыг сэдвийн хүрээнд тодруулан нэг ярилцлагыг 30 минутаас 1.5 цагт багтаан явуулна.

Номинал бүлгийн ярилцлагыг 8-12 хүний бүрэлдэхүүнтэйгээр тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн асуудлаар мэргэжсэн хүмүүсийн оролцоотойгоор тодорхой шийдвэр гарган шийдэлд хүрэх зорилгоор явуулна.

Номинал бүлгийн ярилцлагыг 8-12 хүний бүрэлдэхүүнтэйгээр тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн асуудлаар мэргэжсэн хүмүүсийн оролцоотойгоор тодорхой шийдвэр гарган шийдэлд хүрэх зорилгоор явуулна.

Дельфи бүлгийн ярилцлагаар ихэвчлэн 10-30 хүний бүрэлдэхүүнтэйгээр тодорхой асуудлаар мэргэжсэн хүмүүсийн санаа бодлыг бэлтгэсэн тодорхой асуумжаар зайнаас цуглуулах байдлаар зохион байгуулж болно.

Судалгаанд хамрагдах газар нутаг, хүн амыг сонгох:

Судалгаанд хамрагдах газарзүйн бүс, өвчнөөс хамааран хүн ам ихээр төвлөрсөн, хүн амын дунд эрсдэл үүсэж болох газар нутгийг сонгон явуулна. Тухайн газар нутагт тандах гэж буй өвчний мал, амьтны өвчлөл бүртгэгдсэн, жил бүр байгалийн голомтын тандалт судалгаагаар зоонозын халдварт өвчний үүсгэгч болон эерэг сорьц илэрч, голомт идэвхтэй байгаа нь тогтоогдсон, хил залгаа орших нутагт тухайн судлах гэж буй халдварын байгалийн голомт тэмдэглэгдсэн зэрэгт үндэслэн хүн амын тандалт судалгаа хийх газар нутгийг сонгоно. Голомт тогтоогдоогүй боловч экологи, биологийн нөхцөл бүхий бүс нутгийг хамруулж болно.

Давтамж

Түүврийн ямар загвартай байна түүндээ нийцүүлэн түүврээ сонгоно. Түүвэр хүн амыг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамруулна. Тухайн аймаг, сум, багийн хүн ам нь судалгааны зорилтот бүлэг байна. Зорилтот бүлгээс тархвар судлалын холбогдол агуулсан, илүү эрсдэлтэй байж болох хүнийг судалгаанд сонгон хамруулна. Судалгааны түүвэр хүн ам нь судалгааны төгсгөлд зорилтот бүлгийн хүн амыг төлөөлж чадахуйц байх ёстой. Статистикийн хувьд үнэн магадлал бүхий үр дүнг гаргахын тулд судалгааны түүвэр хүн амын хэмжээг тогтоохдоо орон нутгийн байгалийн голомтын онцлог, өсгөвөр илрэлт, хүн амын тоо зэрэгт үндэслэн компьютерийн Epi info програмыг ашиглан гаргана. Байгаа мэдээлэл, санхүүгийн бололцоо, зохион байгуулалтын асуудлуудыг харгалзан судалгааны зорилтот бүлгийн хүн амыг төлөөлж чадахуйц тоотой байхаар сонгоно. Сум, багийн хүн амыг хамруулах бол түүврийн хувь 10-30, аймаг болон улсын хэмжээнд түүврийн хувь нь нэгээс багагүй байна. Түүврийн хэмжээ 30-с бага бол бага түүвэр болно. Түүврийн хэмжээ хэт бага, түүвэр судалгааны санамсаргүй байх зарчмыг зөрчвөл түүвэрлэлтийн алдаа гарч болох тул анхаарах хэрэгтэй.

Асуумжийг боловсруулах:

Асуумж судалгаа нь судалгаанд оролцогчийн хүн ам зүйн зарим үзүүлэлттэй холбоотой, халдварт өвчнөөс сэргийлэх талаарх мэдлэг, дадал хандлага, эрсдэл тогтоох асуулт бүхий үндсэн 3 бүтэцтэй байна.

Ач холбогдолтой, үр дүнтэй судалгаа хийхийн тулд асуумж боловсруулахдаа асар их зүтгэл анхаарал цаг хугацаа зарцуулах хэрэгтэй. Асуумж нь судалгааны зорилго, судлах асуудалтай холбоо бүхий хувьсууруудыг судалгаанд оролцогчдын онцлогт тохируулан оновчтойгоор илэрхийлсэн асуулт, хариулт бүхий хуудас байна. Асуумж нь товчхон оновчтой байх шаардлагатай. Асуулт тавих хоёр үндсэн хэлбэр байдаг.

- Нээлттэй асуултууд: Энэ хэлбэрийн асуулт нь хариулах олон хувилбарыг хариулагчид олгодог. Чөлөөтэй хариулах боломжтой, хариулагчийн өөрийн үгээр илэрхийлэгддэг, нэгээс олон хариулттай байж болдог, тухайн асуудлаарх оролцогчийн ойлголтыг бүрэн илэрхийлсэн байна. Ийм асуултууд нь зохиоход хялбар байдаг ч кодлох боловсруулалт хийхэд хүндрэлтэй байдаг.
- Бодит асуултууд: энэ хэлбэрийн асуултуудад тэмдэглэх хуудас (*checklists*), олон сонголттой асуултууд болон “үнэн/худал” гэсэн загварын асуултууд орно. Хариултын хувилбарууд нь асуулттайгаа тохирсон байж болох бүх хариултуудыг багтаасан байхад анхаарах хэрэгтэй. Энэ төрлийн асуултыг бөглөх хариултуудыг кодлох боловсруулалт хийхэд хялбар цаг бага зарцуулдаг.

Асуумж авах хугацаа нь 30 минутаас ихгүй байх нь тохиромжтой. Асуумжийн хуудсыг доорх дарааллаар бичдэг. Танилцуулга: Энд судалгааны агуулга, зорилготой холбоотойгоор асуулга явуулж буй шалтгаан ба зорилгыг товч, ойлгомжтойгоор илэрхийлсэн байна. Мөн судалгаа явуулж буй байгууллагын нэр, хариулагч хүний нэр, ярилцлага хийх хугацааг бичнэ. Асуумжаа тааламжтай асуулт ба мэдээгээр эхлэн, асуулт нь энгийнээс нарийн руу чиглэсэн, хоорондоо уялдаа холбоотой, стандарт загварыг ашигласан, ойлгомжтой, оновчтой үг хэллэг ашигласан байна. Асуумж боловсруулсны дараа өмнөх сорил (*pre-testing*) авч шаардлагатай бол шинэчлэн өөрчлөнө.

ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ТАНДАЛТЫН АСУУМЖ СУДАЛГААНЫ ХУУДСЫН АГУУЛГА

Чиглэл	Асуулт	Хариулт	Үнэлгээ
<i>Судалгаанд хамрагдагчийн шинж байдал</i>			
Ерөнхий мэдээлэл:	Овог нэр, нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, мэргэжил	Ерөнхий мэдээллийг мэдлэг хандлага, халдварлах эрсдэлтэй харьцуулан, холбоо хамаарлыг тогтоож, статистикийн үнэн зөв магадлалыг тооцно.	
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшин:</i>			
Өвчний мэдээлэл	Өвчний тухай, эх уурхай, дамжих зам, ертөмхий бие, шинж тэмдэг, голомтын мэдээлэл	Тийм/Үгүй	Зөв хариултууд нийлээд 100 оноо байна.
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Урьдчлан сэргийлэх аргууд, өөргийгөө хэрхэн хамгаалах аргууд, үхсэн амьтантай тааралдах үед авах арга хэмжээ,	Сонголттой, олон хариулттай	
<i>Хандлагыг тогтоох:</i>			
Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл авдаг эх сурвалжууд	Сонголттой, олон хариулттай	Буруу хандлагыг тогтооно.
Урьдчилан сэргийлэх дадал, хандлагууд	Вакцин, хоол хүнсний хэрэглээ, эмнэлэгт хандалт, мал, амьтанд уруулж, ноцуулах, үе хөлтөн шавжинд хазуулсан тохиолдолд авах арга хэмжээ, эдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд (хамгаалах өмсгөлийн хэрэглээ, мал, амьтнаа вакцинжуулах)	Сонголттой, олон хариулттай	
<i>Эрсдлийг үнэлэх</i>			
Судалгаанд оролцогчийн эрсдэл	Хэр удаан амьдарч буй, мал, амьтан тэжээдэг эсэх, ой мод, өвс ихтэй газраар явдаг эсэх, шумуул хачиг, бусад шавжинд хазуулдаг эсэх, зэрлэг мэрэгч амьтантай харьцдаг эсэх, агнадаг эсэх, тарваганы мах хэрэглэдэг эсэх, эрүүл мэндийн тусламж авах хугацаа, байршил	Сонголттой, олон хариулттай	Эрсдэлийг тодорхойлно
Эрсдэлт өртөх шалтгаанууд	Ой мод, өвс ихтэй газраар явах зорилго, эрсдэлд өртсөн газар, хугацаа, давтамж, эрсдэлд өртсөний дараах илрэх шинжүүд	Сонголттой, олон хариулттай	

ТАНДАЛТЫН АСУУМЖ СУДАЛГААНЫ ХУУДАСНЫ ЗАГВАР

Нэг. Ерөнхий мэдээлэл:

Судлаач өөрөө бөглөнө.
Судлаачийн нэр..... Судалгаа хийсэн.....он.....сар.....өдөр:
Судалгаа хийсэн:аймаг, хот.....сум, дүүрэг.....газрын нэр, байр
<u>Судалгаанд оролцогчийн мэдээлэл:</u> Оролцогчийн нэр..... Нас: <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> Хүйс: <input type="checkbox"/> Эмэгтэй <input type="checkbox"/> Эрэгтэй Оролцогчийн гэрийн хаяг:..... Оролцогчийн боловсрол: <input type="checkbox"/> Боловсролгүй <input type="checkbox"/> Бага (1-3 анги) <input type="checkbox"/> Дунд (4-9 анги) <input type="checkbox"/> Бүрэн дунд (10-12 анги) <input type="checkbox"/> Мэргэжил, техникийн <input type="checkbox"/> Дээд Эрхэлдэг ажил:.....
<u>Ийлдсийн мэдээлэл:</u> Ийлдэс өгсөн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол: Ийлдсийн дугаар Оролцогчийн регистрийн дугаар..... Оролцогчийн утасны дугаар.....

ХАЧИГТ ХАЛДВАРЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Хачгаар дамжих өвчний талаар сонссон уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хачгаар дамжих өвчинг хэрхэн хүнд халддаг вэ?	<input type="checkbox"/> Хачигнаас <input type="checkbox"/> Агаараас <input type="checkbox"/> Малаас <input type="checkbox"/> Хүнээс <input type="checkbox"/> Сүүнээс <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Танай бодлоор ямар хачиг өвчин дамжуулдаг вэ?	<input type="checkbox"/> Ойн хачиг <input type="checkbox"/> Бэлчээрийн хачиг <input type="checkbox"/> Загийн шар хачиг <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад
Танай нутагт хачиг хаана их тархалттай байдаг вэ?	<input type="checkbox"/> Ой модтой газар <input type="checkbox"/> Өвс ихтэй газарт <input type="checkbox"/> Заг их ургасан газарт <input type="checkbox"/> Бэлчээрт <input type="checkbox"/> Малд <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хачигт халдвараас хэрхэн сэргийлэх вэ?	<input type="checkbox"/> Хачигт хазуулахгүй байх <input type="checkbox"/> Вакцинд хамрагдах <input type="checkbox"/> Сүүг буцалгаж хэрэглэх <input type="checkbox"/> Хачиг дайжуулагч хэрэглэх <input type="checkbox"/> Малтай хамгаалах хэрэгсэлтэй харьцах <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хачгаар дамжих халдварт өвчний талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио

	<input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Эмч, эмнэлгийн ажилтнаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс <input type="checkbox"/> Дам ярианаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Судалгаанд оролцогчийн дадал, хандлагыг тогтоох:</i>	
Малд болон ойд явахдаа биедээ хачиг шалгадаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол хэзээ	<input type="checkbox"/> Ойд явж байхдаа <input type="checkbox"/> Ойгоос гэртээ ирсэний дараа <input type="checkbox"/> Өвс ихтэй газраар явахдаа <input type="checkbox"/> Малд явж байхдаа <input type="checkbox"/> Гэртээ ирсэний дараа
Хачигт хазуулсан тохиолдолд хачигаа хэрхэн яаж зайлуулдаг вэ?	<input type="checkbox"/> Шууд татаж, сугалж аваад хаях <input type="checkbox"/> Хошууг ганхуулан аваад хаях <input type="checkbox"/> Саванд хийгээд шинжлүүлэхээр өгөх <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хачигт энцефалитын дархлаажуулалтад хамрагдсан эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрв тийм бол	<input type="checkbox"/> I тун онсар.....өдөр <input type="checkbox"/> II тун..... он.....сар.....өдөр <input type="checkbox"/> III тун..... он.....сар.....өдөр
<i>Эрсдлийг тогтоох:</i>	
Та хачигт хазуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм бол хаана явж байгаад хазуулсан бэ?	<input type="checkbox"/> Ойд <input type="checkbox"/> Өвс ихтэй газар <input type="checkbox"/> Бэлчээрт <input type="checkbox"/> Бусад.....
Ямар зорилгоор болон ямар нөхцөлд хазуулсан бэ?	<input type="checkbox"/> Малд <input type="checkbox"/> Жимс, ургамал түүх,

	<input type="checkbox"/> Түлээ мод бэлтгэх <input type="checkbox"/> Хадланд <input type="checkbox"/> Мал хариулах <input type="checkbox"/> Малын үс, ноос, ноолууртай харьцах <input type="checkbox"/> Аялалаар <input type="checkbox"/> Бусад.....
Хэдэн удаа хазуулсан бэ?	<input type="checkbox"/> 1 удаа <input type="checkbox"/> 2-3 удаа <input type="checkbox"/> Олон удаа
Хэдийд хазуулсан бэ?	<input type="checkbox"/> Энэ жил <input type="checkbox"/> Жилийн өмнө <input type="checkbox"/> Хэдэн жилийн өмнө
Хачигт хазуулсаны дараа ямар нэг зовиур илэрч байсан уу?	<input type="checkbox"/> Халуурах <input type="checkbox"/> Толгой өвдөх <input type="checkbox"/> Хэсэг газарт улайж үрэвсэх <input type="checkbox"/> Бүх биеэр цэгчилсэн тууралт гарах <input type="checkbox"/> Том цагирган тууралт гарах <input type="checkbox"/> Дагз хөшиж өвдөх <input type="checkbox"/> Бусад
Дээрх зовиураас болж эмчид хандаж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНИЙ МЭДЛЭГ, ХАНДЛАГА,
ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Танай нутаг тарваган тахлын байгалийн голомттой юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Ямар амьтад тарваган тахал өвчнийг хүнд дамжуулдаг вэ?	<input type="checkbox"/> Тарвага <input type="checkbox"/> Жижиг мэрэгчид (Зурам, огдой, үлийн цагаан г.м) <input type="checkbox"/> Хулгана, харх <input type="checkbox"/> Тэмээ <input type="checkbox"/> Бүүрэг <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хүн ямар замаар халдвар авдаг вэ?	<input type="checkbox"/> Үхсэн тарвага зурамнаас <input type="checkbox"/> Тарваганы бөөс, бүүрэгнээс <input type="checkbox"/> Тарваганы мах, арьс түүхий эдээс <input type="checkbox"/> Халдвар авсан хүнээс <input type="checkbox"/> Бүгд зөв <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад замаар.....
Тарваган тахлаар хүн өвчилбөл ямар шинж тэмдэг илэрдгийг мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм бол	<input type="checkbox"/> Өндөр халуурна, <input type="checkbox"/> Толгой өвдөнө, <input type="checkbox"/> Булчирхай цочино <input type="checkbox"/> Цээжээр өвдөж, цустай цэр гарна <input type="checkbox"/> Гүйлгэж, бөөлжинө <input type="checkbox"/> Хоолой өвдөнө <input type="checkbox"/> Бусад.....
Тарвага агнахыг хориглосон тухай хуулийг мэддэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Хуулийн хугацаа дууссан

	<input type="checkbox"/> Үгүй
Тарваган тахал өвчнөөс та яаж урьдчилан сэргийлэх вэ ?	<input type="checkbox"/> Тарвага агнагүй байх <input type="checkbox"/> Үхсэн тарвага, зурамтай харьцахгүй байх <input type="checkbox"/> Тарвага болон тарваганы түүхий эдтэй харьцахдаа хамгаалах өмсгөл хэрэглэх <input type="checkbox"/> Дархлаажуулалтанд хамрагдах <input type="checkbox"/> Тарваганы махыг болгож хэрэглэх <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад
Тарваган тахал өвчний талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио <input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Эмч, эмнэлгийн ажилтанаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс <input type="checkbox"/> Дам ярианаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Судалгаанд оролцогчийн дадал, хандлагыг тогтоох:</i>	
Та үхсэн тарвага, зурамтай тааралдвал ямар арга хэмжээ авах вэ?	<input type="checkbox"/> Хэрэглээнд ашиглана <input type="checkbox"/> Тарвага, зурмыг авч яаж үхсэнийг нь тодруулна <input type="checkbox"/> Хүрэхгүйгээр малын эмч болон нутгийн захиргаанд яаралтай мэдээлэх <input type="checkbox"/> Мэдэхгүй
Эмчилгээний зориулалтаар тарваганы эд эрхтэнийг түүхийгээр нь хэрэглэдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Танайх эмнэлгийн байгууллагад 24 цагийн дотор хандах боломжтой юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Эрсдлийг тогтоох:	
Та ан хийдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол ямар ан агнадаг вэ?	<input type="checkbox"/> Том араатан амьтад <input type="checkbox"/> Шувуу <input type="checkbox"/> Туулай хэлбэртэн <input type="checkbox"/> Тарвага <input type="checkbox"/> Жижиг мэрэгчид (Зурам, огдой, үлийн цагаан г.м) <input type="checkbox"/> Бусад.....
Тийм бол ямар аргаар агнадаг вэ?	<input type="checkbox"/> Буугаар <input type="checkbox"/> Хавх, урхиар <input type="checkbox"/> Нохойгоор бариулах <input type="checkbox"/> Бусад.....
Та ангын махаа өвчих зэргээр мах, түүхий эдтэй харьцдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол хамгаалах хувцас хэрэглэдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Та тарваган тахлын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрв тийм бол	<input type="checkbox"/> I тун онсар.....өдөр <input type="checkbox"/> II тун..... он.....сар.....өдөр <input type="checkbox"/> III тун..... он.....сар.....өдөр

БООМ ӨВЧНИЙ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Танай нутагт боомоор хүн өвдөж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй
Боомоор ямар амьтад өвчилдөг вэ?	<input type="checkbox"/> 5 хошуу мал <input type="checkbox"/> Гахай <input type="checkbox"/> Нохой <input type="checkbox"/> Зэрлэг амьтад (чоно, үнэг, хярс, зээр, гөрөөс) <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хүн ямар замаар халдвар авдаг вэ?	<input type="checkbox"/> Өвчтэй хүнээс <input type="checkbox"/> Өвчилсөн малын түүхий эдтэй харьцах үед <input type="checkbox"/> Малын хашаа хороо, өтөг бууц цэвэрлэх <input type="checkbox"/> Шавжинд хазуулах <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Боом өвчнөөр хүн өвчилбөл ямар шинж тэмдэг илэрдгийг мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм бол	<input type="checkbox"/> Толгой өвдөж, өндөр халуурна <input type="checkbox"/> Хатиг гарч, цэврүү үүсч, хар тав тогтох <input type="checkbox"/> Ханиалгана, цээжээр өвдөнө <input type="checkbox"/> Бусад.....
Боом өвчнөөс та яаж урьдчилан сэргийлэх вэ ?	<input type="checkbox"/> Вакцин хийлгэх <input type="checkbox"/> Малаа вакцинжуулах <input type="checkbox"/> Малын хашаа хороо, өтөг бууцтай харьцахд хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх <input type="checkbox"/> Өвчтэй малаа малын эмчид үзүүлнэ <input type="checkbox"/> Гараа тогтмол угаах <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад
Боом өвчний талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио <input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Эмч, эмнэлгийн ажилтнаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс

	<input type="checkbox"/> Дам ярианаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэг дадал, хандлагыг тогтоох:</i>	
Шалтгаан тодорхойгүйгээр үхсэн мал, түүхий эдтэй харьцдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрв тийм бол хамгаалах өмсгөл өмсдөг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Шалтгаан тодорхойгүйгээр мал үхвэл та ямар арга хэмжээ авах вэ?	<input type="checkbox"/> Хэрэглээнд ашиглана <input type="checkbox"/> Бусад худалддаг <input type="checkbox"/> Үхсэн тохиолодолд мал эмнэлэгт хэлж, булж устгуулддаг <input type="checkbox"/> Өөрсдөө булж устгадаг <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Та боомын дархлаажуулалтанд хамрагдаж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол хэзээон.....сар.....өдөр
Та боомын сэжигтэй байдлаар өвдвөл ямар арга хэмжээ авах вэ?	<input type="checkbox"/> Эмч дуудаж үзүүлнэ <input type="checkbox"/> Гэрээр эм хэрэглэх <input type="checkbox"/> Эмнэлэгт очиж үзүүлнэ <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Эрсдлийг тогтоох:</i>	
Танай нутаг боомоор мал өвдөж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Малаа боомын вакцинд хамруулдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Та мал гаргах, малын мах эвддэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол энэ үед гараа эсгэх тохиолдол байдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Гараа эсгэсний дараа тэр хэсэгт дараах шинжүүд илэрч байсан уу?	<input type="checkbox"/> Хавдах <input type="checkbox"/> Улайж үрэвсэх <input type="checkbox"/> Хатигших <input type="checkbox"/> Цэврүүтэж, хар тав тогтох <input type="checkbox"/> Бусад.....
Энэ үед ямар арга хэмжээ авсан бэ?	<input type="checkbox"/> Эмч дуудаж үзүүлэх <input type="checkbox"/> Гэрээр эм хэрэглэх <input type="checkbox"/> Эмнэлэгт очиж үзүүлэх <input type="checkbox"/> Бусад.....

ГАЛЗУУ ӨВЧНИЙ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Галзуу өвчнөөр ямар амьтад өвчилдөг вэ?	<input type="checkbox"/> Чоно, үнэг, хярс <input type="checkbox"/> Сарьсан багваахай <input type="checkbox"/> 5 хошуу мал <input type="checkbox"/> Нохой <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Хүн ямар замаар халдвар авдаг вэ?	<input type="checkbox"/> Галзуугаар өвчилсөн мал, амьтанд шүлсдүүлж, уруулж, ноцуулсан үед <input type="checkbox"/> Галзуугаар өвчилсөн мал, амьтантай харьцсан үед <input type="checkbox"/> Нохойд уруулж, ноцуулах үед <input type="checkbox"/> Галзуу өвчнөөр өвчилсөн хүнээс <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Галзуу өвчнөөс та яаж урьдчилан сэргийлэх вэ ?	<input type="checkbox"/> Яаралтай эмнэлэгт хандаж, вакцин тариулна <input type="checkbox"/> Эмчилгээ хийлгэх <input type="checkbox"/> Урсан мал, амьтныг мал эмнэлгийн байгууллагаар устгуулна <input type="checkbox"/> Бусад мал, амьтныг вакцинжуулна <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад
Галзуу өвчний талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио <input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Эмч, эмнэлгийн ажилтнаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс <input type="checkbox"/> Дам ярианаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Судалгаанд оролцогчийн дадал, хандлагыг тогтоох:</i>	
Та мал амьтанд уруулж, ноцуулсан үед ямар арга хэмжээ авдаг вэ?	<input type="checkbox"/> Яаралтай эмнэлэгт хандаж, вакцин тариулна <input type="checkbox"/> Ямар ч арга хэмжээ авдаггүй <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....

Та өмнө нь галзуугийн вакцин хийлгэж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол бүрэн тунд хамрагдсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Галзуугаар мал, амьтан өвчилсөн тохиолдолд та ямар арга хэмжээ авах вэ?	<input type="checkbox"/> Өөрөө алж, устгана <input type="checkbox"/> Мал эмнэлэг болон нутгийн захиргаанд мэдэгдэнэ <input type="checkbox"/> Бусад малаа вакцинжуулна <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Эрсдлийг тогтоох:</i>	
Танай нутаг галзуугар мал, амьтан өвчилж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм бол ямар амьтан өвчилж байсан бэ?	<input type="checkbox"/> Нохой <input type="checkbox"/> Чоно <input type="checkbox"/> Үнэг <input type="checkbox"/> Хярс <input type="checkbox"/> 5 хошуу мал <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Та мал, амьтнаа галзуугийн вакцинд хамруулдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Танай хотонд зэрлэг амьтан орж ирэх, ноцох тохиолдол гарч байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Танай орон нутагт чоно, золбин нохойг зохион байгуулалттай устгадаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй
Та эрүүл мэндийн байгууллагад 24 цагийн дотор хандах боломжтой юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

ШУМУУЛААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН МЭДЛЭГ, ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Шумуулаар дамжих халдварын талаар сонссон уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Танай нутагт шумуул хаана их тархалттай байдаг вэ?	<input type="checkbox"/> Ой модтой газар <input type="checkbox"/> Өвс ихтэй газарт <input type="checkbox"/> Усны ойр орчим <input type="checkbox"/> Ногооны талбайд <input type="checkbox"/> Малын ойролцоо <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Шумуулаар дамжих халдвараас хэрхэн сэргийлэх вэ?	<input type="checkbox"/> Хамгаалдаггүй <input type="checkbox"/> Дайжуулагч тос, шүршигч хэрэглэдэг <input type="checkbox"/> Утаа тавьдаг <input type="checkbox"/> Битүү хувцас өмсдөг <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Шумуулаар дамжих халдварын талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио <input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Эмч, эмнэлгийн ажилтанаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс <input type="checkbox"/> Дам ярианаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Эрсдлийг тогтоох:</i>	
Та шумуулд хазуулдаг уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм	<input type="checkbox"/> Байнга <input type="checkbox"/> Хааяа

	<input type="checkbox"/> Ганц нэг удаа
Хэрэв тийм бол хаана явж байгаад хазуулсан бэ?	<input type="checkbox"/> Гэртээ <input type="checkbox"/> Ажил дээрээ <input type="checkbox"/> Мал, амьтны ойролцоо <input type="checkbox"/> Цэцэрлэгт хүрээлэнд <input type="checkbox"/> Жимс, ногооны талбай дээр <input type="checkbox"/> Гол, нуур, цөөрмийн орчим <input type="checkbox"/> Муу усны нүх, тогтоол усны орчим <input type="checkbox"/> Ус хадгалах савны орчим <input type="checkbox"/> Бусад.....
Шумуулд хазуулсаны дараа ямар нэг зовиур илэрч байсан уу?	<input type="checkbox"/> Улайх <input type="checkbox"/> Хавдах <input type="checkbox"/> Өвдөх <input type="checkbox"/> Загатнах <input type="checkbox"/> Шархалж , үрэвсэх <input type="checkbox"/> Булчирхай цочих <input type="checkbox"/> Халуурах <input type="checkbox"/> Толгой өвдөх <input type="checkbox"/> Бүх биеэр цэгчилсэн тууралт гарах <input type="checkbox"/> Бусад.....
Дээрх зовууриас болж эмчид хандаж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

**ГАХАЙ ШУВУУГААР ДАМЖИХ ХАЛДВАР МЭДЛЭГ,
ЭРСДЛИЙН АСУУМЖИЙН ЗАГВАР**

ААН-ын мэдээлэл:

Судлаач өөрөө бөглөнө.	
Судалгаа хийж буй аж ахуйн нэгжийн нэр.....	
ААН-ын төрөл	<input type="checkbox"/> Шувууны <input type="checkbox"/> Гахайн <input type="checkbox"/> Бусад
ААН-ын зориулалт	<input type="checkbox"/> Өрхийн <input type="checkbox"/> Худалдааны <input type="checkbox"/> Бусад
ААН-ын амьтнытоо..... төрөл	
ААН ажилчдынтоо	
Үйл ажиллагаа эрхэлж буйжил	
ААН-ын амьтдад хийсэн вакцины нэрдавтамж.....	


Ажилчдаас авах асуумж:

Асуулт	Хариултын хувилбар
<i>Судалгаанд оролцогчийн мэдлэгийн түвшинг тогтоох:</i>	
Гахай шувуугаар дамжих өвчний талаар сонссон уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Гахай, шувууны дунд ямар өвчлөл гардаг вэ?	<input type="checkbox"/> Томуу <input type="checkbox"/> Мязан <input type="checkbox"/> Цусан халдвар <input type="checkbox"/> Бусад.....
Гахай шувуугаар дамжих халдварын талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?	<input type="checkbox"/> Телевиз <input type="checkbox"/> Радио <input type="checkbox"/> Сонин <input type="checkbox"/> Малын эмч, эмнэлгийн ажилтнаас <input type="checkbox"/> Интернэтээс <input type="checkbox"/> Найз, нөхдөөс <input type="checkbox"/> Мал эмнэлэг

	<input type="checkbox"/> Удирдлагаас <input type="checkbox"/> Мэдээлэл авдаггүй <input type="checkbox"/> Бусад.....
<i>Судалгаанд оролцогчийн дадал, хандлагыг тогтоох:</i>	
ААН-д халдвагүйтгэл хийдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол хэр давтамжтай	<input type="checkbox"/> Өдөр бүр <input type="checkbox"/> 7 хоногт 1-2 удаа <input type="checkbox"/> Сард нэг удаа <input type="checkbox"/> Улирал тутамд <input type="checkbox"/> Жилд нэг удаа <input type="checkbox"/> Бусад.....
Ямар бодис хэрэглэдэг вэ?	<input type="checkbox"/> Бичнэ үү.....
Та амьтантай харьцахдаа хамгаалах өмсгөл хэрэглэдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Та амьтантай харьцахдаа ямар төрлийн хамгаалах өмсгөл хэрэглэдэг вэ ?	<input type="checkbox"/> Комбинзон иж бүрдэл <input type="checkbox"/> Бээлий <input type="checkbox"/> Амны хаалт <input type="checkbox"/> Усны гутал <input type="checkbox"/> Бусад..... <input type="checkbox"/> Хэрэглэдэггүй
Та гараа хэзээ угаадаг вэ?	<input type="checkbox"/> Малтай харьцсаны дараа <input type="checkbox"/> Малтай харьцахын өмнө <input type="checkbox"/> Хоол идэхийн өмнө <input type="checkbox"/> Бусад..... <input type="checkbox"/> Угаадаггүй
<i>Эрсдэл</i>	
Танай ААН-ын амьтдын дунд өвчлөл, шалтгаан тодорхойгүй үхэл гарч байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй
Энэ тохиолдолд малын эмч дуудаж үзүүлдэг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Хэрэв тийм бол ямар өвчлөл гарч байсан бэ?	Бичнэ үү.....
Үхсэн тохиолдолд хэрхэн устгадаг вэ?	<input type="checkbox"/> Хогын саванд хаядаг <input type="checkbox"/> Булж устгадаг <input type="checkbox"/> Шатааж устгадаг <input type="checkbox"/> Мэдэхгүй <input type="checkbox"/> Бусад.....
Та ажлаа хийж байгаад шалтгаангүйгээр ямар нэг зовиур илэрч байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Хэрэв тийм бол	<input type="checkbox"/> Ханиах <input type="checkbox"/> Бөөлжих <input type="checkbox"/> Гүйлгэх <input type="checkbox"/> Халуурах <input type="checkbox"/> Толгой өвдөх <input type="checkbox"/> Хоолой өвдөх <input type="checkbox"/> Биеэр тууралт гарах <input type="checkbox"/> Арьс шархалж үрэвсэх <input type="checkbox"/> Булчин өвдөх <input type="checkbox"/> Бусад.....
Дээрх зовиураас болж эмчид хандаж байсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Энэ дараах шалтгаануудтай холбоотой байж болох уу?	<input type="checkbox"/> ААН-ээс шалтгаангүйгээр амьтан үхсний дараа <input type="checkbox"/> ААН-д амьтдын дунд өвчлөл гарсны дараа <input type="checkbox"/> Хамгаалалтын хувцас хэрэгсэлгүй ажилласнаас <input type="checkbox"/> Амьтанд хазуулах, уруулах зэрэг бусад..... <input type="checkbox"/> Өөрийн биеийн эсэргүүцэл суларснаас <input type="checkbox"/> Хамт ажилладаг хүн өвдсөнөөс <input type="checkbox"/> Ажилтай холбогдолгүй <input type="checkbox"/> Бусад.....

Төвийн захирлын... оны
... дүгээр сарын ... өдрийн
дугаар тушаалын III хавсралт



ТАНДАЛТЫН ТАЙЛАН БИЧИХ ДАРААЛАЛ

1. Үндэслэл, орон нутгийн суурь мэдээлэл
2. Тандалт судалгааны аргачлал
3. Асуумж судалгааны боловсруулалтын дүн (Хамрагдсан хүн, нас хүйс, нийгэм, газар зүйн онцлог, мэдлэг, хандлагын түвшин)
4. Лабораторийн шинжилгээний дүн
5. Хүн амын дундах тухайн өвчний халдваржилтын хувь (нас, хүйсийн бүтэц, нийгэм, газар зүйн онцлог)
6. Дүгнэлт
7. Зөвлөмж
8. Эргэн мэдээлсэн байдал
9. Хавсралтаар (Батлагдсан удирдамж, зардлын тооцоо, асуумж судалгааны эх хувь, хүснэгтүүд, лабораторийн шинжилгээний дүн, боловсруулсан мэдээлэл файлаар)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БГХӨЭСТ-ийн захирлын 1999 оны а/39 тоот тушаал “Тархвар судлалын шинжилгээний заавар”
- БГХӨСҮТ-ийн 2010 оны а/78 тоот тушаал “Байгалийн голомтот, шинэ сэргэн тархаж буй зарим халдварт өвчний хүн амын дундах тархвар зүйн тандалт судалгааны арга зүйн заавар”
- ЗӨСҮТ-ийн 2012 оны а/38 тоот “Зоонозын Халдварт өвчний тохиолдолд болон үйл явдалд суурилсан тандалтын түр журам”
- ЗӨСҮТ-ийн 2012 оны 2/128 дугаар тушаал “Хачгаар дамжих халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн удирдамж”
- Advocacy, communication and social mobilization for TB control: a guide to developing knowledge, attitude and practice surveys. WHO/HTM/STB/2008.46
- “Guidelines for measuring national HIV prevalence in population-based surveys” UNAIDS/WHO Working Group on Global HIV/AIDS and STI surveillance
- Knowledge, attitudes and practices for risk education: how to implement kap surveys, Fabienne Goutille for Handicap International, 2009